

2.4. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Тайлбар	Гүйцэтгэл/Хэрэгжээгүй бол шалтгаан, нөхцөл, тайлбар	Гүйцэтгэлийн хувь
1	Дорнод аймгийн нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийн ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн бөгөөд хэрэгжүүлэхэд нийт 62.5 тэрбум төгрөг шаардлагатай.	100
2	Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төв байгуулах төсөл	Зураг төсөл боловсруулах	Улаанбаатар хотын баруун бүсийн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх зорилгоор уг төслийг “Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д тусган Сангийн яам руу зөвшөөрөл авах тухай албан бичгийг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улаанбаатар хөгжлийн корпораци ХК-аас хүргүүлсэн. Зүүн бүсийн тээвэр, логистикийн хувьд нийслэлийн зүгээс 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Туушин ХХК-тай Хамтран ажиллах гэрээг байгуулсан. “Нийслэл хотод ачаа тээврийн логистикийн төвд тавигдах стандарт”-ыг боловсруулах ажлыг Хотын стандартын хяналтын газар, холбогдох байгууллагууд хамтарч зохион байгуулж байна. Улаанбаатар хотын баруун хэсгийн тээвэр, логистикийн төв болох “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд нийслэлийн төсвөөс тус төвийн дэд бүтцийн II дугаар ээлжийн дуусгалын ажлын хөрөнгийг баталж, гүйцэтгэгч сонгон шалгаруулан ажлыг эхлүүлсэн.	100
3	Дорноговь аймгийн Сайншанд сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Гурван тэс сумын Шивээ хүрэн боомтод уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн холимог тээврийн терминал байгуулах төсөл	Зураг төсөл боловсруулах	Гашуунсухайт боомтод үерийн далан, чингэлэг тээвэр, урт болон богинын тээврийн зам талбайн ажил, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалт төлөвлөгөөний дагуу хийгдэж, жилдээ <b>10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай уг терминал 2021.09.20-нд ашиглалтад орсон.</b> Чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 2-ны өдрийн 185 дугаар тогтоолын хүрээнд Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг “Монголын Алт” ХХК хийж гүйцэтгэн <b>ашиглалтад оруулсан.</b> Тавантолгой холимог тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах хөрөнгө шийдэх чиглэлээр “Эрдэнэс таван толгой” ХК дээр ажлын хэсэг байгуулагдсан. Тавантолгойн холимог тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ-г боловсруулж логистикийн төвийн барилгын ажлыг эхлүүлсэн. Барилгын ажлын гүйцэтгэгчээр “Бодь интернэйшнл” ХХК ажиллаж байгаа бөгөөд ажлын явц 40%-тай явагдаж байна.	100

4	Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Ховд аймгуудад хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, газар тариалан, хөдөө аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэлд түшиглэсэн орон нутгийн логистикийн төвүүдийг байгуулах	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Зам, тээврийн хөгжлийн яам, Дэлхийн банктай хамтран орон нутгийн эдийн засгийг эргэлтэд оруулахад дэмжлэг болгох зорилгоор логистик, нийлүүлэлтийн сүлжээний платформ байгуулах – Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд байгуулахаар хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн. Ховд аймагт “Шинэ ховд” төслийн хүрээнд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлээд байна.	50
5	Богдхан төмөр зам төсөл	ТЭЗҮ боловсруулах	Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д Засгийн газрын 2021.08.04-ний өдрийн 230 дугаар тогтоолоор олгосон. Батлагдсан Ажлын даалгаврын дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК нь ТЭЗҮ-ийг боловсруулж, техникийн шийдэл, байгаль орчны болон ус зүйн судалгааг тус тус эрх бүхий шинжээч нараар магадлуулж, дүгнэлтийн хамт тус яаманд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн. Магадлагдсан ТЭЗҮ-ийн судалгааны тайланг Төмөр замын салбарын Шинжлэх ухаан, технологийн Дэд зөвлөлөөр 2022-01-07-ны өдөр, Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн Зөвлөлийн 2022-01-11-ний өдрийн өргөтгөсөн хурлаар тус тус хэлэлцүүлж, Дэд зөвлөл, Зөвлөлийн гишүүдээс гаргасан холбогдох саналыг судалгааны тайланд тусгахаар зааж, судалгааны тайланг дэмжихээр тогтсон.	100
6	Улаанбаатар хотын олон улсын төмөр замын төв буудлыг шинэчлэх төсөл	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	МУ-ын 2022 оны төсвийн тухай хуульд хөрөнгө тусгагдаагүй.	-
7	Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	ТЭЗҮ, зураг төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр ЭЗХЯ санал хүргүүлсэн. Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд хүргүүлсэн (2022.10.04-ний 01/4549). Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар ИНЕГ-т хүргүүлсэн (2022.12.06-ны 09/5622). Концессын тухай хуулийн 4.2-д заасны дагуу “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д орон нутгийн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг “Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх” төрлөөр оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлт ЭЗХЯ-нд 2022.12.16-ны өдрийн 01/5835 тоот албан бичгээр хүргүүлсэн.	30
8	Хэнтий аймгийн Жаргалтхаан сум-Өмнөдэлгэр сум-Рашаан хад-Өглөгчийн хэрэм-Биндэр сум-Баян-Адарга сум-Дадал сум чиглэлийн 290 км хатуу хучилттай автозам төсөл	Зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн авто замын эхний ээлжийн Чингис хот-Бэрх чиглэлийн 20 км хатуу хучилттай авто замыг 2019.11.19-ний өдөр Улсын байнгын ашиглалтад оруулсан. Үргэлжлэл Чингис хот-Дадал сум чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замыг барьж гүйцэтгэхээр "Наранбулаг-хан" ХХК шалгарч гэрээ байгуулан гүйцэтгэж, нийт ажлын явц 82 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Өмнөдэлгэр-Биндэр сум хүртэлх 145.12 км хатуу авто замын зураг төсөл хийгдэж дууссан.	100
9	Бүсийн нислэгийн хөдөлгөөний нөөц төв байгуулах төсөл	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Санхүүжилт шийдэгдээгүй.	-
10	Дархан-Эрдэнэтийн автозамаас Амарбаясгалант хийд чиглэлийн	Зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн 33.2 км авто замын зураг төсөл хийгдсэн.	100

	33.2 км хатуу хучилттай автозам төсөл			
11	Завхан аймгийн Нөмрөг сумыг Арцсуурь хилийн боомттой холбох 199 км хатуу хучилттай автозам	Зураг төсөл боловсруулах	Завхан аймгийн Нөмрөг сумыг Арцсуурь хилийн боомттой холбох 159.5 км хатуу хучилттай автозамын зураг төсөл хийгдэж дууссан.	100
12	Булган аймгийн Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн 53,6 км хатуу хучилттай автозам	Зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн 53.7 км авто замын зураг төсөл хийгдсэн.	100
13	Булган аймгийн Гурванбулаг-Хишиг-Өндөр-Орхон чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто зам	Зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн 99.7 км авто замын зураг төсөл хийгдсэн.	100
14	Хэнтий аймгийн Норовлин-Дадал чиглэлийн 75 км хатуу хучилттай авто зам төсөл	Зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн 56 км авто замын зураг төсөл хийгдсэн.	70
15	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бүс нутгийн хэмжээнд хянах төв	Зураг төсөл боловсруулах	БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагатай хамтран 10.5 сая ам.долларын техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр урьдчилсан судалгааны ажлыг хийж, төслийг эхлүүлэх эхний шатны танилцуулгыг хийгээд байна.	50
16	Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх төсөл	Зураг төсөл боловсруулах	Барилга хот байгуулалтын яаманд 2022 он ТЭЗҮ, зураг төсөл боловсруулсан.	100
17	Баян-Өлгий аймгийн Өлгий хот-Улаанхус сум-Алтай таван богд уул чиглэлийн 118 км хатуу хучилттай авто зам	Зураг төсөл боловсруулах	Барилга хот байгуулалтын яаманд 2022 онд ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төслийн жагсаалтад тусгуулахаар Баян-Өлгий аймгийн Өлгий -Улаанхус-Цэнгэл сум хүртэлх 80 км хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах төслийн жагсаалтад тусгагдсан.	-
18	Налайх-Төв аймгийн Баян сум чиглэлийн 58 км автозамыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх төсөл	Зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн авто замын зураг төслийг хийж дууссан.	100
19	Хөвсгөл нуур болон бусад усан замын тээврийн хэрэгсэл хөвөх боломжтой гол, мөрөн, нуурт усан замын дэд бүтэц /хяналтын пост, зогсоол, бусад хөвөгч байгууламж/ байгуулах	Зураг төсөл боловсруулах	Санхүүжилт шийдэгдээгүй.	-
20	Зүүн босоо чиглэлийн төмөр зам	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Концессын зүйлийн жагсаалтад оруулсан. "МТЗ" ТӨҮГ-т концесс эзэмших эрхийг олгосон. Тус газраас концесст хөрөнгө оруулах, хамтран хэрэгжүүлэх байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ хийхээр ажиллаж байна.	30
21	Баруун босоо чиглэлийн төмөр зам	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	БХБЯ болон ЗТХЯ нь Зөвлөх компаниар сонгон шалгарсан "Урбан Девелопмент Консалтинг Групп" ХХК-тай 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдөр "Баруун чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах" ажил гүйцэтгэх, гүйцэтгүүлэх 193 тоот гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Зөвлөх баг эхний, дунд, эцсийн шатны тайланг тус тус гэрээнд заасан хугацаанд ирүүлсэн хэдий ч судалгааны эцсийн тайлан гэрээний үүргийг хангаагүй тул тайланг буцааж, гэрээнд заасны дагуу 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс хуанлийн 30 хоногт багтаан тайланг мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн, үндэслэлтэй	70

			боловсруулж, эдийн засгийн үр ашгийн тооцоог гүйцэтгэн 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр тус яаманд ирүүлэх мэдэгдлийг Зөвлөхөд хүргүүлсэн.	
22	Завханы Доной нисэх буудлыг олон улсын зэрэглэлтэй болгох	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Санхүүжилт шийдэгдээгүй.	-
23	Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	ТЭЗҮ, зураг төсөл хийгдэж дууссан.	100
24	Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт 100 км хатуу хучилттай автозам төсөл /Орхоны гүүр - Төв аймгийн Жаргалант/	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн 92.2 км авто замын зураг төсөл хийгдсэн.	100
25	Улаанбаатар - Мандалговь - Даланзадгад чиглэлийн автозамыг шинэчлэн өргөтгөх	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн 90 км авто замын их засварын ажлын зураг төсөл хийгдсэн.	100
26	Арвайхээр - Мандалговь - Чойр чиглэлийн автозам	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн 505.8 км авто замын зураг төсөл хийгдсэн.	100
27	"Цэцэрлэг хот-Эрдэнэцогт сум-Баянхонгор хот-Баянлиг сум-Гурвантэс сум" хүртэлх 700 км босоо тэнхлэгийн автозамын төсөл	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	Санхүүжилт шийдэгдээгүй.	-
28	Баянхонгор - Шаргалжуут чиглэлийн 56 км автозам, томоохон 4 голд төмөр бетонон гүүр барих төсөл	Зураг төсөл боловсруулах	Тус чиглэлийн 56 км авто замын зураг төсөл хийгдсэн.	70
29	Ховд-Өлгий чиглэлийн автозамаас Ховд, Эрдэнэбүрэн сум хүртэлх, Алтай-Ховд чиглэлийн автозамаас Чандмань сум, Хөшөөтийн уурхай хүртэлх, Мянгад-Дөргөн чиглэлийн автозамаас Дөргөн сум хүртэлх нийт 160 км хатуу хучилттай автозам	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	<p>- Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн сумдыг холбох авто замын зураг төсөл хийгдсэн. барилгын ажлыг АХБ-ны "Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Эрдэнэбүрэн сумыг холбох авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу 2021 оны 11 дүгээр сард эхлүүлсэн. Ховд сумыг холбох авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг ханган Тендерийн баримт бичгийн төслийг АХБ-нд хүргүүлээд байна.</p> <p>- Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто замын зураг төсөл хийгдсэн, барилгын ажлыг хэрэгжүүлсэн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн хавсралтад тусган шийдвэрлэсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>- Хөшөөтийн уурхай нь Ховд аймгийн Цэцэг сумтэй хатуу хучилттай авто замаар холбогдсон ба Цэцэг сумыг Говь-Алтай-Ховд чиглэлийн А0304 улсын чанартай авто замтай холбох ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг Ховд аймгийн 2022 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p>	90
30	Дархан Сэлэнгийн авто замыг 4 эгнээ болгож шинэчлэх	Зураг төсөл боловсруулах	Алтанбулаг-Дархан чиглэлийн 113км авто замын зураг төсөлтэй хамт хийгдсэн.	100

				85.8
--	--	--	--	------

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ